

Ажлын хуудас

Ц.Гомбожав

“Монгол Төвөдөөр аялсан тэмдэглэл “

1899 оны 1 сарын 25. Өргөө хот. Шарын шашны бурхан шүтээнд мөргөхөөр яваа буриад ламын дүрээр хувцасласан миний бие дарван тэмээ хөллөн, Алшаагийн монгол жинчидтэй хамт Өргөөгөөс хөдөллөө...

1901 оны 2 сарын 7. Лхас. Орон нутгийн тооллоор цагаан сар (төвөдөөр ло- сар) гарлаа. Энэ өдөр хотын ард иргэд үүр гэгээрэхээс өмнө босож, эхлээд гэртээ, дараа нь Зуу сүмд мөргөл үйлдэнэ. Үүр цайх үеэр тусгай домботой арвайн дарс,тавагтай замбаа барин танил, хөрш айлууддаа орж, идээ амсуулна. Тавагтай замбаагаа шовойлгон янзлаад дээр нь өвсөн иштэй , тосоор урласан цэцэг хатгана. Үүнийгээ чимар \ тостой замбаа\ гэж нэрлэнэ. Энэ идээгээр дайлуулсан хүн замбаанаас чимхэн авч бурхан тэнгэрт өргөнө. Өөрөө мөн чимхэн авч хүртэнэ. Домботой дарснаас амсана. Энэ өдөр айлд орсон хүнийг мөн ийм идээгээр дайлна. Зуу сүмд бүхэл өдөржиг мөргөл үргэлжилнэ. Хүүхэд, томчууд ч ялгаагүй чүдэнз зурж, харанхуйд ягаан гэрэл гарган наадна. Гудамжинд хэсэг хэсгээрээ дуу дуулан бүжинэ. Залуу бүсгүйчүүд дээс тоглон цэнгэн наадна.

1902 оны 4 сарын 27. Өргөө. Нутаг буцахаар Монголын өртөөгөөр гарч 5 сарын 2 – нд Хиагт хотоор эх орныхоо алтан хилийг алхан орлоо.

Даалгавар

1. Хэн?, Хэзээ?, Хаагуур? Яах гэж? гэсэн асуултаар эхийг хурааж бичээрэй.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

2. Дараах өгүүлбэрийн үйлийн хэлбэржилтийг \ үйлийн ямар нөхцөлөөр хувирсаныг \ ажиглаарай. Зохиогч аян замын тэмдэглэлээ тоочих хэв маягаар бичсэнийг батлан бичээрэй.

Ард иргэд	өмнө босож,		Тайлбар Жишээ нь: үйл явдал нэг цаг хугацаанд зэрэгцэн болж буйг илэрхийлэхдээ зэрэгцэн холбох нөхцөлүүдээр холбож, өгүүлбэрийн төгсгөлийн үйл үгийг үйлийн цагаар төгсгөх “на” нөхцөлөөр хэлбэржүүлэн зэрэгцүүлэн тоочих аргаар бичжээ.
	мөргөл үйлдэнэ.		
	арвайн дарс барин,		
	тавагтай замбаа барин,		
	хөрш айлууддаа орж,	идээ амсуулна.	
	шовойлгон янзлаад,	цэцэг хатгана.	
		гэж нэрлэнэ.	
Хүн	чимхэн авч,		
		бурхан тэнгэрт өргөнө.	
Өөрөө		авч хүртэнэ.	
		дарснаас амсана.	
		идээгээр дайлна.	
Хүүхэд, томчууд ч	чүдэнз зурж,		
		гэрэл гарган наадна.	
		дуу дуулан бүжнэ.	
Бүсгүйчүүд	дээс тоглон,		
		цэнгэн наадна.	

3. Аяллын тэмдэглэлээс ямар шинэ, сонирхолтой мэдээлэл олж авсанаа бичээрэй.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

4. Сонин содон дүрслэл, өвөрмөц үг хэллэг, шинэ мэдээлэл оруулан дүрслэх дуурайх үгээр тодотгон аян замын тэмдэглэл бичээрэй.

- Бичихдээ сурах бичгийн 94-97 –р хуудасны мэдээллийг уншиж судлан бичнэ.
- **95-р хуудасны үг хэллэгээс ашиглаж бичээрэй.**
- Үгийн тоо 120 -150